

**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
2024 ОНЫ 03 ДУГААР УЛИРЛЫН ЯВЦЫН МЭДЭЭ**

2024.10.01

Баруун-Урт

2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны А/701 дүгээр захирамжаар анх баталсан. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 03 дугаар тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний А/09 дүгээр захирамжаар, 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/183 дугаар захирамж, 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/295 дугаар захирамжаар тус тус шинэчлэн хуулийн хугацаанд батлуулсан.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар: 60 нэр төрлийн 20074.5 сая төгрөгийн төсөвтэй бараа, ажил, үйлчилгээний тендерийг зохион байгуулахаас 46 нэр төрлийн 15212.1 сая төгрөгийн төсөвтэй бараа, ажил, үйлчилгээний тендерийг зохион байгуулж гэрээ байгуулах эрхийг олгосон. 12 нэр төрлийн 2968 сая төгрөгийн төсөвтэй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалт эхлээгүй, 2 нэр төрлийн 1131 сая төгрөгийн төсөл арга хэмжээ материал хүлээн авч байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: 20 нэр төрлийн 63193.7 сая төгрөгний бараа, ажил, үйлчилгээний тендерийг зохион байгуулахаас 14 нэр төрлийн 54589.9 сая төгрөгний бараа, ажил, үйлчилгээний тендерийг зохион байгуулж гэрээ байгуулах эрхийг олгосон. Үүнээс:

- Нээлттэй тендер шалгаруулалт: 13 нэр төрлийн 54449.3 /Тавин дөрвөн тэрбум дөрвөн зуун дөчин есөн сая таван зуун/ төгрөгний үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээ
- Харьцуулалтаар 1 нэр төрлийн 136.9 /нэг зуун гучин зургаан сая есөн зуун мянган/ төгрөгний үнийн дүнтэй ажил, үйлчилгээний тендерийг зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

Сүхбаатар аймгийн хэмжээнд зарлагдсан бүх тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр 100 хувь зохион байгуулж, давхардсан тоогоор 116 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын зар, урилга, үр дүнг тухай бүр

нийтэлсэн байна. Зарлагдсан бүх тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.

2024 оны 1-2 дугаар сард 13 сумын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүдтэй тайлан гаргах, төлөвлөгөө үүсгэх талаар болон хуулийн шинэчилсэн найруулгын талаар давхардсан тоогоор нийт 122 иргэн, хуулийн этгээдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Аймгийн Засаг дарга М.Идэрбаттай Худалдан авах ажиллагааны газрын дарга Ө.Тайвансанаа нар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр баталгаажууллаа. Тус төлөвлөгөө нь 4 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт нь 88,8%-тай үнэлэгдсэн байна.

2024 онд Сүхбаатарчууд бид ТББ, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо ТББ, Худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг 3 иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна.

2024.03-06-ны өдөр Аймгийн Засаг даргын Тамгын газарт, 2024-03-19-ний өдөр Баруун-Урт сумын ЗДТГ-ын албан хаагчдад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ танилцуулга, сургалтыг зохион байгуулж, нийт 53 иргэн хамрагдсан байна.

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 04-6-ны өдрүүдэд Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төв НҮТББ-тай хамтран зохион байгуулсан. Тус сургалтад 51 иргэн хамрагдснаас 34 иргэн буюу 66,6 хувь нь шалгалтад тэнцсэн.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ДОТООД АЖИЛ, ХҮНИЙ НӨӨЦ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ГАЛСАНЖАМЦ